



БАЯНГОЛ ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2023 оны 07 сарын 05 өдөр

Дугаар А/251

Улаанбаатар хот

Гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн
байдлын зэрэгт шилжсэнтэй холбогдуулан
авч хэрэгжүүлэх арга хэмжээний тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1.20, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаал, Нийслэлийн Засаг даргын 2023 оны Б/34 дүгээр захирамж, Гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлэх тухай 2023 оны А/732 дугаар захирамж, Дүүргийн онцгой комиссын 2023 оны 07 дугаар сарын 05-ны өдрийн хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Нийслэлийн нутаг дэвсгэрт орсон их хэмжээний борооны улмаас үүссэн үерийн аюул, гамшгийн нөхцөл байдалтай холбогдуулан нутгийн захиргааны байгууллага, иргэн, хуулийн этгээдийг 2023 оны 07 дугаар сарын 05-ны өдрийн 12:00 цагаас 07 дугаар сарын 08-ны өдрийн 00:00 цаг хүртэлх хугацаанд Гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэнтэй холбогдуулан дор дурдсан байгууллага, албан тушаалтанд үүрэг болгосугай.

1.1. Дүүргийн нутаг дэвсгэрт гарч болзошгүй аюулт үзэгдэл, ослоос урьдчилан сэргийлэх, аврах, хор уршгийг арилгах зорилгоор 2023 оны 07 дугаар сарын 05-ны өдрөөс Засаг даргын Тамгын газрын 301 тоотод “Гамшгаас хамгаалах шуурхай штаб”-ыг байгуулж, хариуцлагатай жижүүрийн хуваарь гарган холбогдох албан тушаалтнуудад хүргүүлж, хэрэгжилтийг ханган ажиллахыг Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтэс (М.Солонго)-т;

1.2. Голомтын бүсэд Гамшгаас хамгаалах төлөвлөгөөний дагуу гамшгаас хамгаалах үйл ажиллагааг шуурхай, үр дүнтэй зохион байгуулахыг Онцгой байдлын хэлтэс (Дэд хурандаа Н.Оюунболд)-т;

1.3. Их хэмжээний борооны улмаас үүссэн үерийн аюул, гамшгийн нөхцөл байдалтай холбогдуулан иргэдэд мэдээ мэдээллийг тухай бүр нэгдсэн урсгалаар хүргэж, ажиллахыг дүүргийн Хэвлэл мэдээллийн алба (Л.Оюунгэрэл)-нд, Хорооны Засаг дарга нарт;

1.4. Хариуцсан хорооны нутаг дэвсгэр дэх үүүсч болзошгүй гамшгийн нөхцөл байдлыг тухай бүр тодотгож, Шуурхай штабт 2 цаг тутамд мэдээлж, шаардлагатай арга хэмжээг шуурхай авч ажиллахыг Хорооны Засаг дарга нар, Сууц өмчлөгчдийн холбоодод;

1.5. Гэмт хэргээс урьдчилсан сэргийлэх, арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Цагдаагийн газар (Н.Сумъяа)-т; Эвдэрч хагарал үүссэн газарт замын хөдөлгөөний

1160201650

зохицуулах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Замын Цагдаагийн хэлтэс (Н.Ариунтөгс)-т;

1.6.Хүч хэрэгсэл, гамшгийн болон орон нутгийн нөөцийг дайчлах, нөөцийг нэмэгдүүлэх судалгаа, төлөвлөгөөний дагуу шаардлагатай арга хэмжээ авч ажиллахыг Цагдаагийн газар (Н.Сумъяа), Цэргийн штаб (Л.Цэрэгбаяр), Онцгой байдлын хэлтэс (Дэд хурандаа Н.Оюунболд), Замын цагдаагийн хэлтэс (Н.Ариунтөгс), Эрүүл мэндийн төв (З.Балдандугар), Тохижилт нийтийн аж ахуйн хэлтэс (Г.Мөнх-Эрдэнэ), Хүнс худалдаа үйлчилгээний хэлтэс (Б.Эрдэнэчимэг), Дүүргийн гамшгаас хамгаалах алба, Мэргэжлийн ангиудад;

2.Гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэнтэй холбогдуулан шаардагдах зардлыг тухай бүр Засаг даргын нөөц хөрөнгөөс гүйцэтгэлээр санхүүжүүлж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын Ахлах нягтлан бодогч (Б.Хонгорзул)-д үүрэг болгосугай.

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газар (Б.Нарангэрэл), Онцгой байдлын хэлтэс (Дэд хурандаа Н.Оюунболд)-т тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГЫН
ҮҮРГИЙГ ГҮЙЦЭТГЭГЧ,
ЗАСАГ ДАРГЫН ОРЛОГЧ



Д.ЖАРГАЛСҮРЭН